

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/100/НА-СТА-ТШЗ

Чингис хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	133

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХөрөнгө	Засаг даргын нөөц хөрөнгө
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 377

танай _____-ны № _____-т

ХЭНТИЙ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.НАМЖИЛНОРОВ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

Бараа материалын үлдэгдлийг дутуу тоолж баталгаажуулсан, нөөцийн барааны өвс, тэжээлийг анхан шатны баримтгүй зарлагадсан, Засаг даргын орлогч болон эд хариуцагчийн дансанд төсвийн хөрөнгийг шилжүүлэн зарцуулж, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, янгир нутагшуулах төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, шилэн дансанд мэдээллийг дутуу мэдээлдэг, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлүүд давтан гарсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,597,559.3 мянган төгрөгийг төвлөрүүлэн гүйцэтгэлээр 87.8 хувь буюу 1,418,090.6 мянган төгрөгийг зарцуулж, 179,468.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 8,458.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 54.2 хувь буюу 3,872.6 мянган төгрөгийг зарцуулж, 4,585.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Аудитын гол асуудал

Аудитаар мөнгөн хөрөнгө, бараа материал үндсэн хөрөнгө, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Аудитаар нийт 483,792.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 187,722.7 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 261,489.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 2 хариуцлага тооцох албан шаардлага, 34,580.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 22 зорилтын хүрээнд 139 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 89 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээш түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	197,098,813.88	302,883,741.88
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,690,600.00	1,840,600.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,690,600.00	1,840,600.00
3121	Төгрөг	4,690,600.00	1,840,600.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	4,690,600.00	1,840,600.00
33	АВЛАГА	13,867,988.88	18,453,707.88
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	753,170.64	753,170.64
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	4,585,719.00
335	Бусад авлага	13,114,818.24	13,114,818.24
3351	Байгууллагаас авах авлага	8,011,482.24	8,011,482.24
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,103,336.00	5,103,336.00
34	УРЬДЧИЛГАА	-	88,425,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	88,425,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	133,560,225.00	143,764,434.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	125,000.00	-
354	Хангамжийн материал	107,039,573.00	117,368,782.00
35410	Бичиг хэргийн материал	2,192,680.00	2,761,980.00
35420	Аж ахуйн материал	8,545,390.00	8,125,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	200,000.00	450,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,282,006.00	3,288,000.00
35450	Барилгын засварын материал	7,088,640.00	7,363,000.00
35460	Хүнсний материал	60,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	85,670,857.00	95,380,802.00
35500	Биологийн хөрөнгө	17,700,000.00	17,700,000.00
35600	Мал амьтад	8,695,652.00	8,695,652.00
36	НӨӨЦИЙН БАРАА	44,980,000.00	50,400,000.00
36300	Тэжээлийн нөөц	44,980,000.00	50,400,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,916,285,441.15	3,927,237,597.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,916,285,441.15	3,927,237,597.71
392	Биет хөрөнгө	3,872,341,441.15	3,883,293,597.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,796,238,318.62	1,971,599,382.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(567,440,054.20)	(680,887,983.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	405,696,475.80	609,674,475.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(102,298,216.73)	(138,919,312.21)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	307,298,996.31	347,664,513.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	(166,541,961.70)	(203,509,296.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,576,270.87	49,471,698.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(50,681,085.54)	(48,732,063.37)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,967,915,836.00	1,967,915,836.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(196,791,583.56)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	8,378,264.00	8,378,264.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	264,619,199.84	262,546,891.84
39215	Хуримтлагдсан элэгдэл	(41,420,602.12)	(65,117,224.99)
393	Биет бус хөрөнгө	43,944,000.00	43,944,000.00
39301	Програм хангамж	382,000.00	382,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(382,000.00)	(382,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	43,944,000.00	43,944,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,113,384,255.03	4,230,121,339.59
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	219,887.67	7,995,854.16
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	219,887.67	7,995,854.16
413	Өглөг	219,887.67	7,995,854.16
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	96,887.67	141,834.16
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	22,000.00	4,128,520.00
4136	Бусад өглөг	101,000.00	3,725,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,624,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	101,000.00	101,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,113,164,367.36	4,222,125,485.43
51	Засгийн газрын хувь оролцоо	4,113,164,367.36	4,222,125,485.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	292,461,021.31	292,461,021.31
51101	Өмч: - төрийн	292,461,021.31	292,461,021.31
512	Хуримтлагдсан үр дүн	3,681,246,256.85	3,790,207,374.92
51210	Өмнөх үеийн үр дүн	3,681,246,256.85	3,681,246,256.85
51220	Тайлант үеийн үр дүн	-	108,961,118.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	139,457,089.20	139,457,089.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,113,384,255.03	4,230,121,339.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,230,393,651.84	1,990,155,123.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	746,921,125.84	384,137,525.93
120	Нийтлэг татварын бус орлого	746,921,125.84	384,137,525.93
120001	Хувьцааны ногдол ашиг	-	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	746,921,125.84	384,137,525.93
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,019,300.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	743,901,825.84	384,137,525.93
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,483,472,526.00	1,606,017,598.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,049,526.00	8,458,298.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,128,076.00	2,001,247.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,921,450.00	6,457,051.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,479,423,000.00	1,597,559,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,479,423,000.00	1,597,559,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,451,718,824.11	1,881,194,005.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,451,718,824.11	1,881,194,005.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,147,063,938.53	1,685,405,303.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	591,576,926.19	775,764,814.50
210101	Үндсэн цалин	329,029,783.24	424,357,238.53
210102	Нэмэгдэл	195,207,876.10	283,520,765.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,009,062.22	41,375,000.00
210104	Урамшуулал	10,730,330.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	21,599,874.63	26,511,810.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,685,070.41	92,739,171.92
210201	Тэтгэврийн даатгал	49,478,307.23	62,589,747.35
210202	Тэтгэмжийн даатгал	5,914,969.20	7,735,839.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,940,984.73	3,867,919.75
210204	Ажилгүйдлийн даатгал	2,852,961.92	3,700,597.97
210205	Эрүүл мэндийн даатгал	11,497,847.33	14,845,067.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,359,120.72	61,192,203.54
210301	Гэрэл, цахилгаан	22,632,980.72	36,218,124.64
210302	Түлш, халаалт	21,726,140.00	22,974,078.90
210303	Цэвэр, бохир ус	-	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,231,671.00	45,862,050.00
210401	Бичиг хэрэг	4,804,720.00	6,742,800.00
210402	Тээвэр, шатахуун	24,539,342.00	29,208,965.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,096,609.00	4,103,395.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,238,000.00	5,710,890.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,457,000.00	-
2105	Нормативт зардал	859,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	859,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,907,340.00	6,678,606.66
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	33,333.33
210604	Урсгал засвар	20,607,340.00	6,645,273.33
2107	Томилолт, зочны зардал	17,684,000.00	19,330,000.00
210702	Дотоод албан томилолт	17,684,000.00	19,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	155,226,401.00	203,834,293.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	154,061,508.00	199,742,452.98
210803	Даатгалын үйлчилгээ	-	2,879,685.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,379.00	514,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	737,000.00	554,900.00
210807	Газрын төлбөр	127,514.00	142,556.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	202,534,409.21	480,004,162.71

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,235,375.10	49,612,460.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,000.00	264,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	142,219,034.11	430,127,702.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	304,654,885.58	195,788,702.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,310,943.18	16,320,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	250,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	12,870,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,512,943.18	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,502,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,046,000.00	3,450,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	255,343,942.40	179,468,702.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	255,343,942.40	179,468,702.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	778,674,827.73	108,961,118.07
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	778,674,827.73	108,961,118.07

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,492,040,976.00	1,606,017,598.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,568,450.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	7,568,450.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,568,450.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,568,450.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,484,472,526.00	1,606,017,598.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,049,526.00	8,458,298.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,128,076.00	2,001,247.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,921,450.00	6,457,051.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,479,423,000.00	1,597,559,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,479,423,000.00	1,597,559,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,488,300,226.00	1,511,593,598.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,488,300,226.00	1,511,593,598.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,181,803,890.42	1,311,219,176.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	591,567,686.19	774,790,274.29
210101	Үндсэн цалин	329,020,543.24	408,706,162.68
210102	Нэмэгдэл	195,207,876.10	274,733,379.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,009,062.22	62,216,938.91
210104	Урамшуулал	10,730,330.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	21,599,874.63	29,133,793.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,685,070.41	93,621,685.64
210201	Тэтгэврийн даатгал	49,478,307.23	63,624,455.52
210202	Тэтгэмжийн даатгал	5,914,969.20	7,663,540.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,940,984.73	3,849,770.44
210204	Ажилгүйдлийн даатгал	2,852,961.92	3,682,448.66
210205	Эрүүл мэндийн даатгал	11,497,847.33	14,801,470.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,359,120.72	61,248,203.54
210301	Гэрэл, цахилгаан	22,632,980.72	36,124,124.64
210302	Түлш, халаалт	21,726,140.00	23,124,078.90
210303	Цэвэр, бохир ус	-	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,706,117.00	31,546,385.00
210401	Бичиг хэрэг	4,078,220.00	5,715,900.00
210402	Тээвэр, шатахуун	20,809,088.00	16,760,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,096,609.00	4,197,395.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,626,200.00	4,776,550.00
2105	Нормативт зардал	756,000.00	80,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	756,000.00	80,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,472,390.00	8,158,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,777,550.00	600,000.00
210604	Урсгал засвар	17,694,840.00	7,558,500.00
2107	Томилолт, зочны зардал	17,684,000.00	19,330,000.00
210702	Дотоод албан томилолт	17,684,000.00	19,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	322,940,141.00	259,441,277.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	321,775,248.00	255,349,436.98
210803	Даатгалын үйлчилгээ	-	2,879,685.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,379.00	514,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	737,000.00	554,900.00
210807	Газрын төлбөр	127,514.00	142,556.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,633,365.10	63,002,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,553,365.10	62,293,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,000.00	709,500.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	306,496,335.58	200,374,421.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,310,943.18	16,320,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	250,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	12,870,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,512,943.18	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,502,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,046,000.00	3,450,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	257,185,392.40	184,054,421.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	257,185,392.40	179,468,702.55
213404	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,585,719.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,740,750.00</u>	<u>94,424,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	97,274,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	97,274,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	97,274,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		97,274,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		<u>(97,274,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3,740,750.00	(2,850,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,690,600.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,690,600.00	1,840,600.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	292,461,021.31	139,457,089.20	2,902,571,429.12		3,334,489,539.63
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	292,461,021.31	139,457,089.20	2,902,571,429.12		3,334,489,539.63
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	778,674,827.73		778,674,827.73
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	292,461,021.31	139,457,089.20	3,681,246,256.85		4,113,164,367.36
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	292,461,021.31	139,457,089.20	3,681,246,256.85		4,113,164,367.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	292,461,021.31	139,457,089.20	3,681,246,256.85		4,113,164,367.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	108,961,118.07		108,961,118.07
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	292,461,021.31	139,457,089.20	3,790,207,374.92		4,222,125,485.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,597,559,300.00	1,418,090,597.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,597,559,300.00	1,418,090,597.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,580,977,800.00	1,404,620,597.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	803,509,800.00	774,790,274.29
210101	Үндсэн цалин	420,250,000.00	408,706,162.68
210102	Нэмэгдэл	276,709,800.00	274,733,379.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	67,050,000.00	62,216,938.91
210105	Гэрээт ажлын хөлс	39,500,000.00	29,133,793.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,065,100.00	93,621,685.64
210201	Тэтгэврийн даатгал	72,356,200.00	63,624,455.52
210202	Тэтгэмжийн даатгал	7,920,200.00	7,663,540.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,953,600.00	3,849,770.44
210204	Ажилгүйдлийн даатгал	3,953,600.00	3,682,448.66
210205	Эрүүл мэндийн даатгал	15,881,500.00	14,801,470.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,624,700.00	60,948,203.54
210301	Гэрэл, цахилгаан	40,351,400.00	35,824,124.64
210302	Түлш, халаалт	33,273,300.00	23,124,078.90
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,852,200.00	30,998,385.00
210401	Бичиг хэрэг	6,000,100.00	5,715,900.00
210402	Тээвэр, шатахуун	25,000,000.00	16,212,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,000,000.00	4,197,395.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,045,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,807,100.00	4,776,550.00
2105	Нормативт зардал	1,807,100.00	80,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,807,100.00	80,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,528,300.00	22,014,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,585,200.00	14,526,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943,100.00	-
210604	Урсгал засвар	10,000,000.00	7,488,500.00
2107	Томилолт, зочны зардал	27,000,000.00	19,330,000.00
210702	Дотоод албан томилолт	27,000,000.00	19,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	418,192,800.00	334,434,698.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	408,069,800.00	330,342,857.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	622,800.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	6,014,300.00	2,879,685.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	536,400.00	514,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245,600.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,740,400.00	554,900.00
210807	Газрын төлбөр	963,500.00	142,556.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,397,800.00	68,402,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,848,900.00	67,693,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,548,900.00	709,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,581,500.00	13,470,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,581,500.00	13,470,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,000,000.00	12,870,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,581,500.00	600,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,597,559,300.00	1,418,090,597.45
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,597,559,300.00	1,418,090,597.45
132001	Орон нутгийн төсвөөс	1,597,559,300.00	1,418,090,597.45
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,458,298.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,458,298.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,872,579.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	300,000.00
210301	Гэрэл, цахилгаан	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	548,000.00
210402	Тээвэр, шатахуун	548,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,750,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	600,000.00
210604	Урсгал засвар	1,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,274,579.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,274,579.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,585,719.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	4,585,719.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,458,298.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,458,298.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,001,247.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,457,051.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад 187,722.7 мянган төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Цалингийн зардлыг мөнгөн сууриар хөтөлж 3,665.7 мянган төгрөгөөр буруулж, бараа материалын зарлага, дансны авлагын 7,697.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж бүртгэн авлага бууруулсан.
- Тайлант оны элэгдлийн зардлыг 87,934.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас янгир нутагшуулах 38,925.0 мянган төгрөгийн ажилд төлбөрийг урьдчилж төлсөн боловч, урьдчилж төлсөн зардалд бүртгээгүй.
- Мөрөн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил гүйцэтгүүлэхээр ДИ ТИ БИ ХХК-д 49,500.0 мянган төгрөгийг урьдчилан төлж зардалд бүртгэсэн.

Аудитаар 296,069.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 34,580.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 261,489.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 2 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

3.1 Төлбөрийн акт

1. Бараа материалын тайлангийн нөөцийн бараа данснаас 34,580.0 мянган төгрөгийн өвс, тэжээл, хивгийг анхан шатны баримтгүй зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2 Албан шаардлага

1. Бараа материалын тайланг хагас, бүтэн жилээр бөөн дүнгээр гаргасан, орлого, зарлагын анхан шатны баримтын бүрдүүлэлт, тайлан гаргалт, тооцоо бодолтод бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс тодруулгын тайлан, дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдэлээс 5,713.1 мянган төгрөгөөр, тооллогын бүртгэлээс 1,440.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэж, баталгаажуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-д “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.”, 70 дугаар зүйлийн 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.”, 70.2.2-т “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/ гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Засаг даргын орлогч, эд хариуцагчийн хувийн харилцах дансанд наадам, сургалт, тэмцээн уралдааны зардал, шагнал, сэлбэг хэрэгслийн үнэ 16,420.9 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан нь анхан шатны баримтгүй, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”ын 3.6.6-д “Төсвийн байгууллага нь төрийн сангийн

бүртгэлийн данснаас зөвхөн бэлэн мөнгөний үйлчилгээ авах зорилгоор ЖМС-г картын дансандаа шилжүүлэн авна;” гэснийг зөрчсөн байна.

3. Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөр дээш үнийн дүн бүхий зарлагын 10,339.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 45,947.5 мянган төгрөгийн 6 худалдан авалт, 181,628.5 мянган төгрөгийн 35 хөрөнгө, мөнгө зарцуулах тухай шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

3.3 Хариуцлага тооцох албан шаардлага

1. Нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтыг үндэслэж хөтөлдөггүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй хийдэг, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулдаг зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, хяналт тавиагүйгээс зөрчил давтагдаж өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага ... биелүүлээгүй ... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын дарга, нягтлан бодогчид хариуцлага тооцох 2 албан шаардлагыг томилсон эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 58,154.4 мянган төгрөгийн санхүүгийн асуудлын зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс: Загруулсан		Загруулагдаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн зардлыг мөнгөн сууриар хөтөлж 3.6 сая төгрөгөөр буруулж, бараа материалын зарлага, дансны авлагын 7.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж бүртгэн авлага хаасан.	1	11,363.7			1	11,363.7	1	11,363.7				
Үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардлыг 87.9 сая төгрөгөөр дутуу бүртгэж, хуримтлагдсан элэгдлийг зөрүүлсэн.	1	87,934.0			1	87,934.0	1	87,934.0		-		-
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас янгир нутагшуулах 38.9 сая төгрөгийн ажлыг Агнуур судлалын нийгэмлэг ТББ-тай гэрээ байгуулж, урьдчилгаа төлсөн боловч, гэрээний хугацаанд хэрэгжээгүй, нутагшуулах 12 янгирыг Богдхан уулнаас барих зөвшөөрөл олгогдоосгүйтэй холбоотой гэрээний хугацааг сунгасан.	1	38,925.0	1	38,925.0			1	38,925.0				
Мөрөн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил гүйцэтгүүлэхээр ДИ ТИ БИ ХХК-д 49.5 сая төгрөгийг урьдчилан шилжүүлж зардалд бүртгэсэн.	1	49,500.0	1	49,500.0			1	49,500.0				
Дүн	4	187,722.7	2	88,425.0	2		4	187,722.7				-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	Тоо	Дүн	
Бараа материалын тайланг хатагс, бүтэн жилээр бөөн гаргасан, орлого, зарлагын анхан шатны баримтын бүрдүүлэлт, тайлан гаргалт, тооцоо бодолтод бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс тодруулгын тайлан, дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдэлээс 5.7 сая төгрөгөөр, тооллогын бүртгэлээс 1.4 сая төгрөгөөр дутуу бүртгэж, баталгаажуулсан.										
Бараа материалын тайлангийн нөөцийн бараа данснаас 34.6 сая төгрөгийн өвс, тэжээл, хивгийг анхан шатны баримтгүй зарлагдсан.	1	34,580.0	1	34,580.0						
Засаг даргын орлогч, эд хармуцагчийн хувийн харилцах дансанд наадам, сургалт, тэмцээн уралдааны зардал, шалнал, сэлбэг хэрэгсэлийн үнийг шилжүүлэн зарцуулсан нь анхан шатны баримтгүй, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй байна.	1	16,420.9			1	16,420.9				
Нагтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтыг үндэслэж хөтөлдөггүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй хийдэг, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулдаг зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, хяналт тавиагүйгээс зөрчил давтагдаж өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	2	-						2		
Дүн	5	58,154.4	1	34,580.0	2	23,574.4	-	-	2	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Үүнээс							
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн системд Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5.2 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 45.9 сая төгрөгийн 6 худалдан авалт, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 181.6 сая төгрөгийн 35 шийдвэрийг мэдээлээгүй.	1	237,915.0	-	-	1	237,915.0	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байхгүй								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	237,915.0	-	-	1	237,915.0	-	-



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 71-А2370448

Чингис хот

ХЭА-2026/100/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын тайлангийн нөөцийн бараа данснаас 34,580,000.00 (гучин дөрвөн сая таван зуун наян мянга) төгрөгийн өвс, тэжээл, хивгийг анхан шатны баримтгүй зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн." гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Анхан шатны баримтгүй зарцуулсан 34,580,000.00 (гучин дөрвөн сая таван зуун наян мянга) төгрөгийн өвс, тэжээлийн зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй тус байгууллагын дарга Н.Намжилноровоор төлүүлж, аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын дарга Н.Намжилноровт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 218-А2370448

Чингис хот

ХЭА-2026/100/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөр дээш үнийн дүн бүхий зарлагын 10,339,000.00 (арван сая гурван зуун гучин есөн мянга) төгрөгийн 2 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 45,947.478.00 (дөчин таван сая есөн зуун дөчин долоон мянга дөрвөн зуун далан найм) төгрөгийн 6 худалдан авалт, 181,628.500.00 (нэг зуун наян нэгэн сая зургаан зуун хорин найман мянга таван зуу) төгрөгийн 35 хөрөнгө, мөнгө зарцуулах тухай шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг ил тод мэдээлдэггүй, хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Н.Намжилноров, нягтлан бодогч Б.Нандин-Эрдэнэ нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 219-А2370448

Чингис хот

ХЭА - 2026/100/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын тайланг хагас, бүтэн жилээр бөөн дүнгээр гаргасан, орлого, зарлагын анхан шатны баримтын бүрдүүлэлт, тайлан гаргалт, тооцоо бодолтод бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс тодруулгын тайлан, дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдлээс 5,713,052.00 (таван сая долоон зуун арван гурван мянга тавин хоёр) төгрөгөөр, тооллогын бүртгэлээс 1,440,480.00 (нэг сая дөрвөн зуун дөчин мянга дөрвөн зуун ная) төгрөгөөр дутуу бүртгэж, баталгаажуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-д "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.", 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.", 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/ гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын үлдэгдлийг тоолж, баталгаажуулдаггүй, бүртгэлээр хяналт тавьдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Н.Намжилноровт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА





ХЭНГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 220 - А2370448

Чингис хот

ХЭА-2026/100/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засаг даргын орлогч, эд хариуцагчийн хувийн харилцах дансанд наадам, сургалт, тэмцээн уралдааны зардал, шагнал, сэлбэг хэрэгслийн үнэ 16,420,900.0 (арван зургаан мянга дөрвөн зуун хорин мянга есөн зуу) төгрөгийг шилжүүлэн зарцуулсан нь анхан шатны баримтгүй, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.6.6-д "Төсвийн байгууллага нь төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвхөн бэлэн мөнгөний үйлчилгээ авах зорилгоор ЖМС-г картын дансандаа шилжүүлэн авна," гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг эд хариуцагчийн хувийн харилцах дансанд шилжүүлдэг, хяналтгүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Н.Намжилноровт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Б.АРИУНАА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 221-А2370448

Чингис хот

ХЭА-2026/100/НА-СТА-ТШЗ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтыг үндэслэж хөтөлдөггүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй хийдэг, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулдаг зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, хяналт тавиагүйгээс зөрчил давтагдаж өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага ... биелүүлээгүй ... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Засаг даргын тамгын газрын дарга Н.Намжилноровт сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг сумын Засаг дарга Н.Хатанбаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Б.АРИУНАА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 222 - А2370448

Чингис хот

ХЭА - 2026/100/НА-СТА-ТШЗ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтыг үндэслэж хөтөлдөггүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй хийдэг, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулдаг зөрчлүүд дахин давтагдаж, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага ... биелүүлээгүй ... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч Б.Нандин-Эрдэнэд сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Засаг даргын тамгын газрын дарга Н.Намжилноровт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ТАНБААТАР

АУДИТОР

Б.АРИУНАА

